



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 758

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 36,215,256.00 (гучин зургаан сая хоёр зуун арван таван мянга хоёр зуун тавин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Даваажуав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201739

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 4 дугаар сарын 28-ны өдрийн
 58... дугаар тогтоолын хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРҮҮГИЙН
 ЦАГДААГИЙН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ (ш)	Нэгжийн үнэ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг
Таблет Samsung Sm-T295 A8	2020.01.31	44.00	750,000.00	33,000,000.00	-	33,000,000.00
Таблет хэвлэгчийн хамт	2020.04.27	4.00	803,814.00	3,215,256.00	-	3,215,256.00
Нийт дүн				36,215,256.00	-	36,215,256.00
				(гучин зургаан сая хоёр зуун арван таван мянга хоёр зуун тавин зургаан төгрөг)		(гучин зургаан сая хоёр зуун арван таван мянга хоёр зуун тавин зургаан төгрөг)